



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.БАЯРМАА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.09.04 № ХЭГ/3017
танай 2026.07.28-ны № 44 -т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Танаас зам, тээврийн ослын нөхцөл байдал, түүнийг бууруулах асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайд, Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга нараас ирүүлсэн хариуг хавсралтаар хүргүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265008854



МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Наадамчдын зам 1200, Арцатын ам,

23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,

Улаанбаатар хот, 17100

Утас: (976-11) 32 39 77, 32 71 99

Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2026.09.01 № 01/5542

талай _____ -ны № _____ -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА

Танаас 2026 оны "Асуулгын хариу бэлтгүүлэх тухай" ХЭГ/2698 дугаартай албан бичгээр ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн Зам, тээврийн ослын нөхцөл байдал, түүнийг бууруулах асуудлаар тавьсан асуулгын хариуг бэлтгэн хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт/1. хуудастай.

Хүндэтгэсэн,

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Б.ПҮРЭВДАГВА

1726140519

ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын энэ оны 08 дугаар сарын 10-ны өдрийн "Асуулгын хариу бэлтгүүлэх тухай" ХЭГ/2698 дугаар албан бичгийн хүрээнд дараах мэдээлэл, судалгааг хүргүүлж байна. Үүнд:

1.2026 оны Үндэсний их баяр наадмын амралтын өдрүүдэд улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн осол, түүнээс шалтгаалсан нас баралт, гэмтлийн дэлгэрэнгүй статистикийг аймаг, нийслэл, замын чиглэл, нас, хүйс, тээврийн хэрэгслийн төрлөөр гаргасан судалгааг хоёрдугаар;

2.2021-2025 оны баяр наадмын үеийн зам тээврийн ослын статистик, түүнд хийсэн дүн шинжилгээг гуравдугаар;

3.Ослын үндсэн шалтгааны ангилал тус бүрээр нь (хурд хэтрүүлсэн, согтууруулах ундаа хэрэглэсэн, гүйцэж түрүүлэх, ядаргаа, хамгаалах бүс, техникийн бүрэн бус байдал, замын нөхцөл байдал, замын нөхцөл, тэмдэг тэмдэглэгээ, мал амьтан, цаг агаар болон бусад) гаргасан тоо, хувь бүхий судалгааг дөрөвдүгээр хавсралтаар тус тус хүргүүлж байна.

4.Осол хамгийн их гардаг авто замын хэсгүүдийн эрсдэлийн үнэлгээ, өмнө хийсэн аудит, өгсөн үүрэг, хэрэгжилтийн талаарх мэдээллийн талаар:

Тээврийн цагдаагийн албанаас жил бүр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг бодитой тодорхойлох, ослоос урьдчилан сэргийлэх арга зам, цаашдын чиг хандлагыг тодорхойлох зорилгоор "Статистик мэдээллийн эмхэтгэл"-ийг 2012 оноос эхлэн гаргаж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүргийн байгууллагуудад хүргүүлж, мэдээлэл солилцон үйл ажиллагаандаа ашиглаж байгаагийн зэрэгцээ зам тээврийн осол, зөрчлийн нөхцөл байдлын бүртгэл мэдээллийг өдөр тутам хөтлөн нөхцөл байдалд тохирсон хариу арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Дүн шинжилгээ, судалгаа хийх (код-715) журам"-ын дагуу цагдаагийн байгууллагын мэдээллийн санд бүртгэгдсэн замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ, судалгаа хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, цаашдын чиг хандлага, хэтийн төлөвийг тодорхойлж, шийдвэр гаргах зорилгоор "Дүн шинжилгээ, судалгааны баг"-ийг байгуулан зам тээврийн осол, зөрчлийг бууруулах ажил арга хэмжээг зохион байгуулж байна. Тухайлбал:

-Зам тээврийн осол, хэрэг их гардаг газар, байршлын судалгаанд үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024-2025 онд Монгол Улсын авто замын хэвтээ, босоо тэнхлэгийн дагуу "Орон нутгийн замын хөдөлгөөний хяналтын хурд хэмжигч, зөрчлийн телекамер"-ын 70 цэгийг ашиглалтад оруулсан;

-Улаанбаатар хотоос гадагш 150 км радиуст гарч байгаа зам тээврийн ослын улмаас хүний амь хохирох, гэмтэх тохиолдол, их гардаг хэсгүүдэд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор "Хөдөлгөөнт хяналтын тасаг"-ийг байгуулж, 24 цагийн хөдөлгөөнт эргүүлийн хяналтыг зохион байгуулснаар тухайн орчимд 2025 оны байдлаар бүртгэгдсэн зам тээврийн осол, хэрэг 14,7, хүний амь нас хохирсон тохиолдол 37,9, гэмтсэн хүн 29,5, мөргөлдөх хэлбэрээр үйлдэгдсэн зам тээврийн осол 13,6, онхолдох хэлбэрээр үйлдэгдсэн зам тээврийн осол 37,1 хувиар, 2026 оны эхний хагас жилийн байдлаар бүртгэгдсэн зам тээврийн осол, хэрэг 15,4, хүний амь нас хохирсон тохиолдол 50,0, гэмтсэн хүн 40,0, мөргөлдөх хэлбэрээр үйлдэгдсэн

зам тээврийн осол 18,2, онхолдох хэлбэрээр үйлдэгдсэн зам тээврийн осол 42,2 хувиар тус тус буурсан эерэг үр дүн гарсан.

-Зам тээврийн осол гарахад зам, замын хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал чухал нөлөөтэй бөгөөд мэргэжлийн байгууллагатай хамтарсан үзлэг шалгалтыг тогтмол зохион байгуулж, холбогдох чиг үүргийн байгууллага, албан тушаалтны хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, замын эвдрэл гэмтлийг засах, тэмдэг, тэмдэглэлийг сайржуулах, нойр сэргээгч, амрах бүс, аюулгүйн зогсолтын зурвас байгуулах арга хэмжээг авсаар байна. Үүнд:

✓ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А/101 дүгээр тушаалаар баталсан "Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам"-ын 3.2 дахь хэсэгт заасны дагуу зам, замын байгууламж, замын хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгах ажлын хүрээнд Улаанбаатар, Төв, Булган, Өвөрхангай, Архангай, Завхан, Увс зэрэг 6 аймгийн 2026,3 километр олон улс, улсын чанартай авто замд 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд;

✓ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон ДЭМБ, Зам, тээврийн яам, Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах төрийн бус байгууллагатай хамтран "Монгол Улс дахь замын аюулгүй байдалд хөрөнгө оруулах, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний төсөв, хөрөнгө оруулалтын стратегийг боловсруулах нь" төслийн хүрээнд "Улаанбаатар-Говьсүмбэр, Дорноговь-Замын-Үүд босоо тэнхлэгийн А0101, А0102, А0103 чиглэлийн авто замуудад 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс 06 дугаар сарын 12-ны өдрийн хооронд нийт 680 километр авто замд замын эвдрэл, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал болон Дорноговь аймгийн Сайншанд, Өргөн, Эрдэнэ, Улаанбадрах, Замын-Үүд сумын нутаг дэвсгэрийн 213 километр авто замд зам тээврийн осол, хэрэг давтамжтай гарч, хүний амь хохирсон 5 байршлын авто зам, замын байгууламжид үзлэг шалгалт хийж зөвлөмж хүргүүлж ажилласан.

✓ Тээврийн цагдаагийн албаны даргын 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Орон нутгийн авто замын үзлэг шалгалтуудыг зохион байгуулж нийт 21 аймгийн Засаг даргын Тамгын газарт албан мэдэгдэл хүргүүлж, 133,582м2 нөхөөсний ажлыг хийж, 558 ширхэг тэмдгийг шинээр байрлуулж, 212 ширхэг тэмдгийг засварлуулах ажлыг хийж гүйцэтгүүлсэн.

✓ Энэ онд Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн энэ оны 06 дугаар сарын 12-ны өдөр баталсан Булган, Өмнөговь, Хэнтий аймгуудын цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалт явуулах удирдамжийн хүрээнд Дорноговь, Хэнтий, Өмнөговь, Булган аймгийн чиглэл дэх замуудад үзлэг шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах зөвлөмжийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад хүргүүлсэн.

5.Баяр наадмын үеэр Засгийн газар, Цагдаа, Зам тээвэр, Эрүүл мэнд, Онцгой байдал болон орон нутгийн байгууллагуудаас зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан төсөв, үр дүнг байгууллага тус бүрээр гаргасан мэдээллийн талаар:

Зуны улиралд нийслэлээс орон нутаг, аялал жуулчлалын бүс нутгийг чиглэсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн эрс нэмэгдэж, улмаар орон нутгийн авто замд зам тээврийн осол гарах, хүний амь нас, эрүүл мэнд хохирох эрсдэл нэмэгддэг. Ялангуяа

тээврийн хэрэгслийн хурд хэтрүүлэх, гүйцэж түрүүлэх үйлдлийг буруу хийх, согтуугаар болон жолоочийн ажил, амралтын горим алдагдсан, ядарсан, нойр дутуу үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, хамгаалах бүс хэрэглэхгүй байх зэрэг жолоочийн сахилга, хариуцлагатай холбоотой зөрчил нь осол, эрсдэлийг нэмэгдүүлэх үндсэн хүчин зүйл болж байна.

Үүнтэй холбогдуулан цагдаагийн байгууллагаас дээрх нөхцөл байдал, Үндэсний их баяр наадмын үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд оролцогчдын хууль сахих хандлага, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор мэдээлэл, нөлөөлөл, соён гэгээрүүлэх, хяналт шалгалт болон урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг жил бүр зохион байгуулж, хэрэгжүүлж ирсэн.

Тухайлбал, 2019 оноос эхлэн тухайн жилийн нөхцөл байдал, осол, зөрчлийн шалтгаан, эрсдэлийн онцлогт тулгуурлан “Яараад яахав дээ”, “Дураараа биш дүрмээрээ”, “Ирээдүйгээ хамгаалъя”, “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ”, “Нэг зам – Нэг соёл”, “Амь аврах алтан гурвалжин”, “Шугаман эргүүл-Хар хэсэг”, “Дүрмээ мөрдье”, “Амраад аюулгүй аялъя” зэрэг нөлөөллийн аян, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, замын хөдөлгөөнд оролцогчдод чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажил болон хяналт шалгалтыг уялдуулан зохион байгуулсаар байна.

Дээрх арга хэмжээний хэрэгжилтийн хугацаанд зам тээврийн осол, ослын улмаас хүний амь нас хохирсон болон гэмтсэн үзүүлэлтүүдэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад тодорхой хувиар буурсан зэрэг өөрчлөлт гарсан. Үүнд:

- 2019 онд (06 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 23-ны өдрийн хооронд) “Яараад яахав дээ”, “Дураараа биш дүрмээрээ” арга хэмжээний хүрээнд нийт зам тээврийн осол 50.8 хувиар, ослоор амь насаа алдсан хүний тоо 11.7 хувиар, гэмтсэн хүний тоо 49.7 хувиар тус тус буурсан;

- 2020 онд (07 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдрийн хооронд) “Яараад яахав дээ” арга хэмжээний хүрээнд нийт осол 22.4 хувиар, амь нас хохирсон хүний тоо 23.4 хувиар, гэмтсэн хүний тоо 26.9 хувиар тус тус буурсан;

- 2021 онд (06 дугаар сарын 25-ны өдрөөс 08 дугаар сарын 10-ны өдрийн хооронд) “Ирээдүйгээ хамгаалъя” арга хэмжээний хүрээнд нийт осол 5 хувиар, амь нас хохирсон хүний тоо 33.3 хувиар, гэмтсэн хүний тоо 25.5 хувиар тус тус буурсан;

- 2022 онд (06 дугаар сарын 20-ны өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд) “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” арга хэмжээний хүрээнд нийт осол 8.1 хувиар, гэмтсэн хүний тоо 0.1 хувиар буурсан хэдий ч амь нас хохирсон хүний тоо 59.2 хувиар өссөн;

- 2023 онд (06 дугаар сарын 30-ны өдрөөс 08 дугаар сарын 18-ны өдрийн хооронд) “Нэг зам-Нэг соёл” арга хэмжээний хүрээнд нийт осол 17.9 хувиар, амь нас хохирсон хүний тоо 5.7 хувиар, гэмтсэн хүний тоо 6.3 хувиар өссөн;

- 2024 онд (05 дугаар сарын 15-ны өдрөөс 09 дүгээр сарын 23-ны өдрийн хооронд) “Шугаман эргүүл-Хар хэсэг” арга хэмжээний хүрээнд авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 40.2, амь хохирсон тохиолдол 34.2, гэмтсэн хүн 47.4 хувиар буурсан;

- 2025 онд (06 дугаар сарын 23-ны өдрөөс 07 дугаар сарын 21-ний өдрийн хооронд) “Дүрмээ мөрдье” арга хэмжээний хүрээнд нийт осол 17.7 хувиар, амь нас хохирсон хүний тоо 35.7 хувиар буурсан боловч гэмтсэн хүний тоо 9.8 хувиар өссөн;

- 2026 онд (06 дугаар сарын 25-ны өдрөөс 07 дугаар сарын 25-ны өдрийн хооронд) “Амраад аюулгүй аялъя” нийт зам тээврийн ослын тоо 17.8, гэмтсэн хүний

тоо 5.6, хүүхэд өртөж гэмтсэн ослын тоо 3.9 хувиар тус тус буурсан боловч амь нас хохирсон хүний тоо 5.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Цагдаагийн байгууллага нь зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөлөл сурталчилгаа, хяналт шалгалтын үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагын дэмжлэг, туслалцааг нийгмийн хариуцлагын хүрээнд авч хамтран зохион байгуулж ирсэн бөгөөд дээрх ажилд зарцуулах төсвийг тусгайлан зааж зохицуулах шаардлагатай байна.

Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулж буй төсөв хөрөнгийн талаарх мэдээллийг аймаг, нийслэл, сум дүүргийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс авах боломжтой.

6.2021-2025 оны дүн шинжилгээ, зөвлөмжийн хэрэгжилт болон 2026 онд ижил эрсдэл давтагдсан шалтгааны талаарх Засгийн газрын дүгнэлтийн талаар:

Засгийн газрын 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар зам тээврийн осол, нас баралт болон хүнд гэмтлийг бууруулах НҮБ-ын Ерөнхий ассамблейн тогтоол, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай конвенц зэрэг олон улсын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, салбар хоорондын уялдааг сайжруулах үүрэг бүхий Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийг байгуулан ажиллаж эхэлсэн.

7.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын удирдлага, холбогдох байгууллагуудын чиг үүргийн уялдаа, мэдээлэл солилцоо, хариуцлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр төлөвлөж буй шинэчлэлийн талаар:

Цагдаагийн байгууллагаас Замын хөдөлгөөний аюулгүй байдлын удирдлага, холбогдох байгууллагуудын чиг үүргийн уялдааг ханган дараах ажил, арга хэмжээг хамтран зохион байгуулсан.Тухайлбал:

-Тээврийн хэрэгслийн техникийн ерөнхий шаардлага Монгол Улсын стандарт MNS 4598:2025-ыг шинэчлэн баталсан. Тус стандартыг шинэчлэн боловсруулахдаа "Овор ихтэй ачааны тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага" MNS 5345:2011, "Хүнд даацын автотээврийн хэрэгсэл. Техникийн ерөнхий шаардлага" MNS 6278:2011 стандартуудын шаардлагыг нэгтгэн тусгаж, автотээврийн хэрэгслийн ангилал, техникийн байдалд тавих ерөнхий шаардлагыг нэгдсэн байдлаар зохицуулах эрх зүйн үндэс бүрдэж, бүх төрлийн тээврийн хэрэгслийг L, M, N, O, T, C, R, S, G, P, LS, V зэрэг ангилалд хамааруулж, техникийн ерөнхий шаардлагуудыг тодорхой болгож өгсөн бөгөөд стандартын хэрэгжилтийг хангуулах ажлыг холбогдох чиг үүргийн байгууллагатай хамтран зохион байгуулж байна.

-Өсвөр насны хүүхэд, залуучууд цахилгаан хөдөлгүүрт унадаг дугуй, скүтер, мопед, мотоцикл унаж, замын хөдөлгөөнд оролцох явдал эрс нэмэгдэж, зам тээврийн осолд өртөж өөрт болон бусдад эрүүл мэнд, эд материалын хохирол учруулах, бусдын хэвийн аюулгүй зорчих эрхэд нөлөөлөх, стресс бухимдалд оруулах нөхцөл үүссэн.

Нөхцөл байдалтай холбоотойгоор Хууль зүй, дотоод хэргийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны А/177 / А/130 дугаар тушаалаар "Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм"-д нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, Засгийн газрын 2025 оны 263 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан.

-Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орохтой холбоотой дагаж Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай болон

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж батлуулсан.

Дээрх хуулийн өөрчлөлтүүдэд баруун гар талдаа жолооны хүрдтэй механикжсан тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулах зорилгоор импортлохыг хориглох, Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн, ослын газрыг орхиж зугтаасан, бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд торгох шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэхгүй байх, зарим зөрчилд эрх хасах, 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, даатгалын тохиолдолд Цагдаагийн байгууллагыг оролцуулахгүй байх хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохирлыг барагдуулахдаа үнэлгээний тайлан шаардахгүйгээр эд хөрөнгийг засуулахаар тохиролцох зэрэг бодлогын ач холбогдол бүхий өөрчлөлтүүд болсон.

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгаар Дэлхийн банкны санхүүжилтээр "Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр" төслийн хүрээнд Улаанбаатар хотын хэмжээнд "Зам тээврийн ослын бүртгэл, мэдээллийн систем хөгжүүлж, суурилуулах зөвлөх үйлчилгээ STRA C-7" төслийг хэрэгжүүлж, TRL Technologies India Private Limited компани зүгээс "Зам тээврийн ослын бүртгэл, мэдээллийн шинэ платформ болон хөдөлгөөнт төхөөрөмжийн аппликейшн"-ыг хөгжүүлж байна.

-Нэгдсэн Үндэстний Байгууллагын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын сангийн дэмжлэгтэйгээр "Монгол Улс дахь замын аюулгүй байдалд хийх хөрөнгө оруулалт: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний төсөв, хөрөнгө оруулалтын стратегийг боловсруулах нь" төслийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Зам, тээврийн яамтай хамтран хэрэгжүүлж байна.

-“Ухаалаг Улаанбаатар хот” төслийн хүрээнд Нийслэл хотын 135 уулзвар, 41 явган хүний гарц, нийт 176 байршилд “AI” бүхий хиймэл оюун ухаанд суурилсан 2606 хяналтын камерыг суурилуулж, холбох ажлыг дуусган зөрчил илрүүлэх ажилд “Өгөгдөл боловсруулах-IREX” системийн программыг нэвтрүүлж, Монгол Улсын Засгийн газрын 239 дүгээр тогтоолоор батлагдсан Замын хөдөлгөөний дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн зөрчилд хариуцлага тооцох ажлыг эхлүүлсэн бөгөөд цаашид үйл ажиллагааг сайжруулахаар ажиллаж байна.

-Зам тээврийн ослын даатгалын тохиолдлын талаарх мэдээлэл, баримтыг цахимаар автоматжуулсан системээс хүлээн авч, нөхөн төлбөрийг шийдвэрлэх талаар сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор Албан журмын даатгагчдын холбоо болон даатгагч байгууллагуудыг нэгтгэж дуудлага, мэдээллийг шуурхай хүлээн авах “Call center” буюу дуудлага, мэдээллийн төвийг байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамд тусгай дугаар олгох хүсэлтийг хүргүүлээд байна.

Цаашид цагдаагийн байгууллагаас дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд:

-Мэргэжлийн байгууллагатай хамтран зам тээврийн осол ихээр гардаг /хар цэг/-үүдэд дундаж хурдны камерын систем байршуулах боломжтой, дэд бүтцэд холбогдсон 8 аймгийн 36 байршлыг энэ оны 05 дугаар сарын 28-аас 06 дугаар сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд тодорхойлсон бөгөөд шинээр нэмж суурилуулахад шаардагдах зардлыг шийдвэрлүүлэх;

-Зам тээврийн яамнаас боловсруулсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын төсөлд санал өгч, батлуулах ажлыг эрчимжүүлэх;

-Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах саналын төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Засгийн газрын шийдвэр гаргуулах;

-Боловсролын сайд, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2026 оны А/74, А/46 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэгт ажиллаж, удирдамжид заасан "Мэргэжлийн сургалтын хөтөлбөрт дүгнэлт гаргах, баталгаажуулах журам", "Мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчийн чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх журам", "Мэргэжлийн сургалтын байгууллагад тавих шаардлага", "Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөр", "Жолооны багшийн үнэмлэх олгох журам, жолооны багшийн үнэмлэхийн загвар", "Автотээврийн салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох журам"-ыг боловсруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, холбогдох саналыг боловсруулан тусгайлан батлуулах;

-Эрүүл мэндийн сайдын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль дагаж гарах журам, шаардлага, жагсаалт, үзлэгийн хуудасны загварын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, холбогдох саналыг хүргүүлсэн хэдий ч ажлын хэсгийн үйл ажиллагаа тодорхойгүй, үр дүнгүй байгааг анхаарч холбогдох саналыг хүргүүлэх;

-Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон этгээдийн жолоодох эрхийг бүх насаар нь хасах тухай хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны төслийг хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагын хүрээнд өнөөгийн хууль эрх зүйн орчин, осол зөрчлийн нөхцөл байдал, олон улсын туршлага бусад хүчин зүйлийн нөлөөллийн шинжилгээ, харьцуулсан судалгааг хийж, холбогдох саналыг хүргүүлэх;

-Улаанбаатар хотоос гадагш чиглэсэн буюу 100-150 км хүртэлх автозамуудыг 2 зорчих хэсэгтэй 4 эгнээтэй барьж байгуулах саналыг хүргүүлэх, Налайх, Дархан чиглэлийн замыг дээрх зохион байгуулалтаар хийснээр ослыг 50 хүртэлх хувиар бууруулсантай ижил түвшний үр дүнд хүрэх;

-Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил гаргагчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх, эрх зүйн зохицуулалтад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хүргүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх.

8.2027 оноос баяр наадмын үеийн болон орон нутгийн авто замын осол, нас баралтыг бууруулах Засгийн газрын нэгдсэн бодлого, тусгай төлөвлөгөө, эрх зүйн шинэчлэл, хөрөнгө оруулалт, хэмжигдэхүйц зорилт, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийн талаар:

Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2026 онд (06 дугаар сарын 15-ны өдрөөс 07 дугаар сарын 25-ны өдрийн хооронд) "Амраад аюулгүй аялъя" арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд нийт осол 5.7, амь нас хохирсон хүний тоо 5.7 хувиар өссөн боловч бүртгэгдсэн зам тээврийн осол 17.8, гэмтсэн хүн 5.6, хүүхэд өртөж гэмтсэн осол 3.9 хувиар тус тус буурсан үр дүн гарсан.

Арга хэмжээний хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагуудад хүсэлт хүргүүлж, авто замын 717 тэмдэг шинээр байрлуулж, 421 тэмдэг засварласан бол 54,469 м.куб авто замд засвар арчлалт хийлгэсэн.

Олон улсын болон улсын чанартай авто зам болон сум суурин, аялал жуулчлалын бүс нутгийг холбосон авто замуудад 185 цэгт 520 алба хаагч үүрэг

гүйцэтгэж, нийт 177350 тээврийн хэрэгсэлд үзлэг, шалгалт хийж 141,760 зөрчил илрүүлсэн.

Дээрх үзүүлэлтээс үзэхэд баяр наадмын үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх, мэдээлэл, нөлөөллийн арга хэмжээ нь зам тээврийн осол, түүнээс үүдэлтэй хохирлыг бууруулахад тодорхой үр нөлөө үзүүлж байгаа хэдий ч ослын улмаас хүний амь нас хохирох эрсдэл бүрэн буураагүй байна.

Тухайлбал, нийт ослын тоо буурсан жилүүдэд ч амь нас хохирсон хүний тоо өссөн үзүүлэлт гарсан нь ослын хүндрэлийн түвшин, осол гарах нөхцөл, шалтгаан, эрсдэлийн хүчин зүйлд чиглэсэн арга хэмжээг илүү нарийвчлан хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Иймд:

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах.

а.Зам тээврийн ослын "Төрөлжсөн сан"-тай болох ажлыг эрчимжүүлэх, ашиглалтгүй байнгын сангуудыг ажиллагаанд оруулж, хамтын ажиллагааны уялдаа, мэдээлэл солилцох үйл ажиллагааг сайжруулах;

б.Монгол Улсын хилээр техникийн шаардлага хангахгүй, стандарт бус техник, хэрэгслийг оруулж ирэхийг хориглох;

с.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг иргэн, албан тушаалтан бүр хэрэгжүүлэх;

д.MNS ISO 39001:2014 Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо-Зааврыг хэрэглэх хэрэгцээ шаардлагыг бүрэн нэвтрүүлэх;

2.Зам, орчны аюулгүй байдлыг сайжруулж, олон улсын стандартад нийцүүлэх.

е.Давхар түвшний огтлолцолгүй зам, гүүрэн байгууламж /явган хүний нүхэн гүүрэн гарам/

ф.Хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл замын тэмдэг, тэмдэглэл, гэрэл дохио, гэрэлтүүлэг, хайс хашлагыг сайжруулах;

г.Нийцтэй зүйлийг нэгтгэх-Нийцгүй зүйлийг тусгаарлах арга хэмжээг авах.

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ӨДРҮҮДЭД БҮРТГЭГДСЭН
ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ**
(2021-2026 оны статистик мэдээнд үндэслэсэн тайлан)

1.Товч танилцуулга

Энэхүү тайланд Үндэсний их баяр наадмын өдрүүдэд (2021-2026 он) бүртгэгдсэн зам тээврийн ослын тоо, ослоор нас барсан, гэмтсэн хүний тоог оноор, бүс нутаг, тээврийн хэрэгслийн төрөл, хохирогчийн хэлбэр (жолооч/зорчигч/явган зорчигч/дугуйтай хүн), нас, хүйсээр задлан шинжилж тусгасан бөгөөд дүн шинжилгээнд үндэслэн баяр наадмын өдрүүдэд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх практик санал зөвлөмжийг боловсруулав.

2.Ерөнхий чиг хандлага (2021-2026)

2021-2024 онд осол, нас барсан, гэмтсэн хүний тоо тогтмол огцом өсч, 2024 онд бүх үзүүлэлт хамгийн өндөр түвшинд хүрсэн. 2025-2026 онд ослын тоо бага зэрэг буурсан хэдий ч 2021 оны түвшнээс 7-8 дахин их хэвээр байна.



Зураг 1. Наадмын өдрүүдэд бүртгэгдсэн осол, нас барсан, гэмтсэн хүний тоо (2021-2026)

Он	Осол	Өсөлт/бууралт	Нас барсан	Өсөлт/бууралт	Гэмтсэн	Өсөлт/бууралт
2021	34	—	3	—	1	—
2022	149	+338.2%	8	+166.7%	21	+2000.0%
2023	246	+65.1%	11	+37.5%	42	+100.0%
2024	332	+35.0%	21	+90.9%	59	+40.5%
2025	290	-12.7%	8	-61.9%	67	+13.6%
2026	266	-8.3%	16	+100.0%	62	-7.5%

Гол ажиглалт:


- Осол 2021-2024 онд 34-өөс 332 болж ~10 дахин өссөн; 2025-2026 онд 290, 266 болж бага зэрэг буурсан ч өндөр хэвээр байна.

- Нас барсны тоо 2024 онд 21 хүнд хүрч оргил цэгт хүрсэн, 2025 онд 8 хүн болж огцом буурсан, харин 2026 онд дахин 16 хүн болж 2 дахин өссөн нь эргэлт буцалттай өөрчлөлт байгааг харуулж байна.

- Гэмтсэн хүний тоо 2021-2025 онд тасралтгүй өссөн (1→67), 2026 онд бага зэрэг (62) буурсан.

3.Бүс нутгаар (Аймаг, Нийслэл)

Нийслэлд бүртгэгдсэн ослын тоо жил бүр аймгийн нийт ослоос 2-3 дахин их байна. Энэ нь Улаанбаатар хотод тээврийн хэрэгслийн төвлөрөл, замын хөдөлгөөний нягтшил өндөр байгаатай холбоотой гэж дүгнэж болно. Гэвч 2022 оноос хойш аймгийн ослын тоо ч мөн тогтмол өссөн (63→89) хэдий ч 2026 онд буурсан (70) байна.



Зураг 2. Аймаг, Нийслэлээр бүртгэгдсэн осол (2021-2026)

Он	Аймаг	Нийслэл	Нийт
2021	0	34	34
2022	63	86	149
2023	78	168	246
2024	80	252	332
2025	89	201	290
2026	70	196	266

4.Тээврийн хэрэгслийн төрлөөр

Суудлын автомашин жил бүр ослын дийлэнх хувийг (78-86%) эзэлж байгаа бол ачааны машин 7-12%, мотоцикл 3-6% байна. 2026 онд механизм болон мотоциклын ослын хувь харьцангуй тогтвортой байгаа хэдий ч мотоциклтой холбоотой нас баралт (доор 5-р хэсэгт) сүүлийн жилүүдэд өссөн нь анхаарал татаж байна.



Зураг 3. Ослын тээврийн хэрэгслийн төрлөөр хуваарилалт (2021-2026)

Он	Суудлын	Ачааны	Автобус	Механизм	Мотоцикл	Унадаг дугуй	Бусад
2021	27 (79%)	4 (12%)	2 (6%)	0 (0%)	0 (0%)	1 (3%)	0 (0%)
2024	277 (83%)	26 (8%)	10 (3%)	0 (0%)	13 (4%)	3 (1%)	3 (1%)
2026	224 (84%)	25 (9%)	5 (2%)	1 (0%)	8 (3%)	1 (0%)	2 (1%)

5.Хохирогчийн бүлгээр (хэлбэр, нас, хүйс)

5.1.Явган зорчигчийн эрсдэл огцом өсч байна.

Гэмтсэн явган зорчигчийн тоо 2021-2022 онд бараг бүртгэгдээгүй байсан бол 2023 онд 11, 2024 онд 21, 2025 онд 34 болж хурдацтай өссөн (2026 онд 28). Энэ нь баяр наадмын өдрүүдэд явган зорчигчийн хөдөлгөөн, зам гарц, гэрэлтүүлэгийн дутагдалтай холбоотой байж болзошгүй тул тусгайлан анхаарах шаардлагатай асуудал юм.




Зураг 4. Явган зорчигчийн эрсдэл: гэмтсэн, нас барсан хүний тоо (2021-2026)

Он	Жолооч	Зорчигч	Явган зорчигч	Дугуйтай хүн
2021	0	1	0	0
2022	6	15	0	0
2023	6	23	11	2
2024	24	11	21	3
2025	12	17	34	4
2026	11	21	28	2

5.2.Насны бүлгээр:

Судалгаагаар 18-34 насныхан жил бүр хамгийн их тоогоор гэмтэж, нас бардаг бөгөөд энэ насны бүлэг нийт хохирогчдын дийлэнхийг эзэлж байна. Үүнээс гадна 0-17 насны хүүхэд, өсвөр насныхны гэмтэл 2022 оноос хойш огцом өссөн (6→19), энэ нь тэдний зам хөдөлгөөний аюулгүй байдалд илүү анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.



Зураг 5. Насны бүлгээр гэмтсэн хүний тоо (2021-2026)

Он	0-17	18-34	35-55	55-с дээш
2021	0	1	0	0
2022	6	8	3	4
2023	12	19	7	4
2024	13	19	18	9
2025	19	25	18	5
2026	17	19	17	9

5.3.Хүйсээр:

Нас барсны 60-70 хувь эрэгтэй хүмүүс байдаг бол гэмтсэн хүмүүсийн хувьд эрэгтэй, эмэгтэй хүний харьцаа харьцангуй тэнцвэртэй (2026 онд эрэгтэй 42, эмэгтэй 20 буюу эрэгтэйчүүд арай их).

6.Дүгнэлт:

Сүүлийн 6 жилийн статистикаас харахад баяр наадмын өдрүүдэд бүртгэгдсэн зам тээврийн осол, хохирогчийн тоо 2021 оноос хойш мэдэгдэхүйц өссөн бөгөөд 2024 онд оргил цэгтэй, дараа нь бага зэрэг буурсан хэдий ч анхны түвшингээс хол зайд байна. Гол эрсдэлт хүчин зүйлс нь: (1) суудлын автомашины эрчимжсэн хөдөлгөөн, (2) Нийслэлийн замын ачаалал, (3) явган зорчигчийн өсөн нэмэгдэж буй эрсдэл, (4) 18-34 насны залуучуудын осолд өртөх өндөр давтамж, (5) мотоциклтой холбоотой нас баралтын сүүлийн үеийн өсөлт. Эдгээр хүчин зүйлсийг тусгасан зорилтот бодлого, урьдчилан сэргийлэх ажил шаардлагатай байна.

7.Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх санал зөвлөмж:

Дээрх дүн шинжилгээнд үндэслэн Наадмын өдрүүдэд зориулсан дараах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1.Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтыг эрчимжүүлэх. Наадмын өдрүүдэд Нийслэлд бүртгэгдэх осол тогтмол хамгийн их байдаг тул төв замууд, наадмын талбай орчимд цагдаа, замын хөдөлгөөний удирдамжийн ажилтныг нэмэгдүүлж, түгжрэл ихтэй цагуудад (өглөө, орой) хяналтыг эрчимжүүлэх.

2.Согтууруулах ундаа хэрэглэсэн жолоочийг илрүүлэх шалгалтыг эрчимжүүлэх. Наадмын баяраар архи, согтууруулах ундаа хэрэглэлт нэмэгддэг тул орой, шөнийн цагаар согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгах хөдөлгөөнт постыг нийслэл, аймгийн төв замуудад нэмэгдүүлэх.

3.Явган зорчигчийн аюулгүй байдлыг сайжруулах. Явган зорчигчийн гэмтэл сүүлийн жилүүдэд огцом өссөн тул наадмын талбай, зах, худалдаа наймаа төвлөрсөн газруудын ойролцоо явган хүний гарц, гэрэлтүүлэг, хамгаалалтын хашлагыг түр байдлаар нэмэгдүүлэх, шаардлагатай бол тодорхой хэсэгт хурд хязгаарлах, зорчигчийн замыг тусгаарлах.

4.Мотоцикл жолоодох дүрэм, хамгаалах хэрэглэлийн хяналтыг чангатгах. Мотоциклтой холбоотой нас баралт сүүлийн жилүүдэд өссөн тул малгай (дуулга) зүүх, үнэмлэхтэй жолоодох дүрмийн мөрдөлтийг шалгах тусгай ажиллагааг зохион байгуулах.

5.18-34 насны залуу жолооч, зорчигчид чиглэсэн ухамсарын кампанит ажил. Хамгийн их хохирогч бүхий насны бүлэг тул сошиал медиа, орон нутгийн телевиз, радио ашиглан хурд хэтрүүлэх, гар утас ашиглах, аюулгүйн бүслүүр зүүхгүй байх зэрэг эрсдэлтэй зан үйлийн эсрэг зорилтот сургалт, сэрэмжлүүлэг явуулах.

6.Хүүхэд, өсвөр насныхны аюулгүй байдалд анхаарах. 0-17 насны хүүхдийн гэмтэл өссөн тул хүүхдийн суудал/аюулгүйн бүслүүрийн хэрэглээг эцэг эх, жолоочид сануулах, сургууль, орон нутгийн удирдлагатай хамтран зуны амралтын өдрүүдэд хүүхдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалт зохион байгуулах.

7.Аймгийн болон хөдөө орон нутгийн замын аюулгүй байдлыг сайжруулах. Аймгийн ослын тоо тогтвортой өндөр байгаа тул орон нутгийн зам, гарц, тэмдэг тэмдэглэгээг Наадмын өмнө нөхөн засварлах, шаардлагатай газарт хурд хязгаарлах тэмдэг байрлуулах, орон нутгийн цагдаагийн хүчийг бэхжүүлэх.

8.Олон нийтийн тээврийг дэмжих, хувийн тээврийн ачааллыг бууруулах. Наадмын үеэр наадмын талбай, зочид буудал, аймгийн чиглэлд нэмэлт

шуудан/автобусны чиглэл зохион байгуулж, хувийн тээврийн хэрэгслийн хэт ачааллыг бууруулах замаар ослын эрсдэлийг бууруулах.

9.Онцгой байдал, түргэн тусламжийн бэлэн байдлыг хангах. Ослын тоо ихэссэн үед хохирлыг бууруулахад түргэн тусламжийн бригад, эмнэлгийн бэлэн байдлыг наадмын өдрүүдэд, ялангуяа их хэмжээний хүн цугларах газруудад нэмэгдүүлэх.

10.Мэдээллийн тогтолцоог сайжруулж, жил бүр дүн шинжилгээ хийх. Ослын мэдээллийг он, сар, цаг, байршил, шалтгаанаар нарийвчлан бүртгэж, Наадмын дараа үр дүнг тухайн жилийн урьдчилан сэргийлэх ажилтай харьцуулан үнэлж, дараа жилийн төлөвлөгөөнд тусгах тогтолцоог бэхжүүлэх.

--oOo--

ОСЛЫН ҮНДСЭН ШАЛТГААНЫ АНГИЛАЛ ТУС БҮРЭЭР ГАРГАСАН ТООН СУДАЛГАА

Ослын үндсэн шалтгааны ангилал тус бүрээр нь (хурд хэтрүүлсэн, согтууруулах ундаа хэрэглэсэн, гүйцэж түрүүлэх, ядаргаа, хамгаалах бүс, техникийн бүрэн бус байдал, замын нөхцөл байдал, замын нөхцөл, тэмдэг тэмдэглэгээ, мал амьтан, цаг агаар болон бусад) гаргасан тоо, хувь бүхий судалгааг танилцуулж байна. Үүнд:

Нэг. Улсын хэмжээний нөхцөл байдал

Үзүүлэлт	2026.07 сар	2025	Өөрчлөлт
Нийт бүртгэгдсэн дуудлага	75,499		
Нийт бүртгэгдсэн осол	13,434	14,500	-7.4%
Нас баралт	367	344	+6.7%
Гэмтсэн хүн	1,914	2,117	-9.6%
Бүртгэгдсэн гэмт хэрэг	2,815	2,686	+4.8%

- Нийт ослын 76.3 хувь нь зөвхөн орон нутгийн замд бүртгэгдсэн.
- Ослын нийт тоо буурсан боловч хүний амь нас хохирсон осол болон бодит нас баралтын эрсдэлд анхаарах шаардлагатай.
- Гэмтсэн хүний тоо 9.6 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Хоёр. Хангайн бүс (Архангай, Баянхонгор, Өвөрхангай)

Осол	Нас барсан	Гэмтсэн	Гэмт хэрэг
201	41	74	236

Гол шалтгаан:

- Зогсоох арга хэмжээ аваагүй 45
- Анхаарал болгоомжгүй үйлдэл 40
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 36
- Эсрэг урсгалд орсон 10

Дүгнэлт, анхаарах асуудал:

- Осол өмнөх оноос 24.4 хувиар буурсан.
- 41 нас баралтын 22 буюу 53.7 хувь нь онхолдох хэлбэрээр үйлдэгдсэн.
- Архангай аймаг бүсийн өндөр үзүүлэлттэй боловч илрүүлсэн зөрчил бага байна.

Гурав. Баруун бүс (Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд)

Осол	Нас барсан	Гэмтсэн	Гэмт хэрэг
362	37	101	330

Гол шалтгаан:

- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 77
- Анхаарал болгоомжгүй үйлдэл 71
- Зогсоох арга хэмжээ аваагүй 43
- Ухрах үйлдэл буруу хийсэн 19

Дүгнэлт, анхаарах асуудал:

- Ховд аймагт нас барсан хүний тоо 62.5%-иар өссөн.
- Ховд аймгийн гэмт хэргийн өсөлт бүсийн үзүүлэлтэд голлон нөлөөлсөн.
- Алслагдсан урт шулуун замд хурд, согтуугаар жолоодох хяналтыг эрчимжүүлэх шаардлагатай.

Дөрөв. Хойд бүс (Булган, Орхон, Хөвсгөл)

Осол	Нас барсан	Гэмтсэн	Гэмт хэрэг
293	40	69	247

Гол шалтгаан:

- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 47
- Зогсоох арга хэмжээ аваагүй 38
- Уулзвар, гарц нэвтрэх журам зөрчсөн 34
- Явган зөрчигчид зам тавьж өгөөгүй 16

Дүгнэлт, анхаарах асуудал:

- Осол буурсан боловч Хөвсгөл, Булган аймагт үзүүлэлтүүд өндөр өсөлттэй.
- Аялал жуулчлал, хөдөлгөөн ихтэй чиглэлд хурд, гүйцэж түрүүлэх хяналтыг нэмэгдүүлэх.
- Сургууль, хүүхдийн хөдөлгөөн ихтэй хэсгийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх.

Тав. Төвийн бүс (Дархан-Уул, Сэлэнгэ, Төв)

Осол	Нас барсан	Гэмтсэн	Гэмт хэрэг
609	60	143	324

Гол шалтгаан:

- Анхаарал болгоомжгүй 146
- Зогсоох арга хэмжээ аваагүй 128
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 80
- Хажуу хоорондын зай тохируулаагүй 59

Дүгнэлт, анхаарах асуудал:

- Нийт дүнгээр осол, нас баралт, хүүхэд өртсөн осол буурсан эерэг үзүүлэлттэй.
- Төв аймагт нас барсан хүний тоо 12.9 хувиар өссөн.
- Төв аймагт онхолдох хэлбэрийн 204 осол бүртгэгдсэн.

Зургаа. Зүүн бүс (Дорнод, Сүхбаатар, Хэнтий)

Осол	Нас барсан	Гэмтсэн	Гэмт хэрэг
309	32	57	321

Гол шалтгаан:

- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 85
- Анхаарал болгоомжгүй 76
- Зогсоох арга хэмжээ аваагүй 36
- Уулзвар, гарц нэвтрэх журам зөрчсөн 20

Дүгнэлт, анхаарах асуудал:

- Осол өмнөх оноос 22.4 хувиар буурсан.
- Сүхбаатарын осол, хохирол болон Хэнтийн нас баралт өссөн.

- Согтуугаар жолоодох зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох хяналтыг эрчимжүүлэх шаардлагатай.

Долоо. Говийн бүс (Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь)

Осол	Нас барсан	Гэмтсэн	Гэмт хэрэг
558	70	93	302

Гол шалтгаан:

- Анхаарал болгоомжгүй 113
- Зогсоох арга хэмжээ аваагүй 80
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 61
- Гүйцэж түрүүлэх үйлдэл буруу хийсэн 24

Дүгнэлт, анхаарах асуудал:

- Осол, хүний амь нас хохирсон осол болон нас баралт өссөн.
- Өмнөговь аймгийн өсөлт бүсийн нийт үзүүлэлтэд голлон нөлөөлсөн.
- Уул уурхай, экспортын чиглэлд хүнд даацын тээврийн хэрэгсэл, хурд, жолоочийн ажил-амралтын горимд хяналт шаардлагатай.

Найм. Нийслэлийн нөхцөл байдал (төвийн 6 дүүрэг)

Дүүрэг	Осол	Нас барсан	Гэмтсэн	Хүүхэд өртсөн осол	Гэмт хэрэг
Баянгол	1,753	8	189	44	125
Баянзүрх	3,649	18	372	96	263
Сүхбаатар	1,379	5	199	47	106
Сонгинохайрхан	1,488	27	231	59	214
Хан-Уул	2,170	18	231	65	169
Чингэлтэй	519	4	134	31	109

- Осол өмнөх оны мөн үеэс 6.6, хүүхэд өртсөн осол 11.2, хүүхдийн нас баралт 27.3 хувиар буурсан.
- Хүний амь нас хохирсон осол 14.9, бодит нас баралт 14.5, бүртгэгдсэн гэмт хэрэг 1.0 хувиар өссөн.
- Сонгинохайрхан дүүрэг нас баралт хамгийн өндөр буюу 27, явган зорчигчийн нас баралт 19.
- Баянзүрхэд гэмт хэргийн тоо 263 буюу хамгийн өндөр, Баянгол, Сонгинохайрхан дүүрэгт урьдчилан сэргийлэх арга хэмжээг түлхүү чиглүүлэх шаардлагатай.

Ес. Алслагдсан 3 дүүрэг (Багануур, Багахангай, Налайх)

Дүүрэг	Осол	Нас барсан	Гэмтсэн	Хүүхэд өртсөн осол	Гэмт хэрэг
Багануур	26	1	14	11	32
Багахангай	10	0	1	1	2
Налайх	108	6	6	3	35

- Багануурт хүүхэд өртсөн осол 5.5 дахин, гэмтсэн хүүхдийн тоо 6.5 дахин өссөн.

- Налайхад хүний амь нас хохирсон осол өсөж, гэмт хэрэг 2.3 дахин нэмэгдсэн.
- Багахангайд нөхцөл байдал тогтвортой байна.
- Багануур, Налайхад хурд хэтрүүлэх, согтуугаар жолоодох зөрчлийн хяналт болон хүүхдийн аюулгүй байдлын арга хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай.

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

1.Улсын хэмжээнд ослын нийт тоо буурсан боловч нас баралтын үзүүлэлт өссөн тул хүний амь нас хохирсон ослын эрсдэлийг бууруулахад хяналт, урьдчилан сэргийлэлтийг чиглүүлэх.

2.Орон нутгийн урт шулуун болон хөдөлгөөн ихтэй авто замд хурд хэтрүүлэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, гүйцэж түрүүлэх үйлдэлд чиглэсэн хяналтыг эрчимжүүлэх.

3.Говийн бүсэд уул уурхай, экспортын тээврийн чиглэлд хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хурд, жолоочийн ажил-амралтын горимд тавих хяналтыг нэмэгдүүлэх.

4.Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол дүүргүүдийн явган зорчигч болон хүүхэд өртөх эрсдэлтэй цэгүүдэд урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг түлхүү хэрэгжүүлэх.

5.Сургууль орчим, хүүхдийн хөдөлгөөн ихтэй хэсэг, явган хүний гарц болон эрсдэл өндөртэй цэгүүдийн аюулгүй байдлыг сайжруулах.

6.Зөрчлийн илрүүлэлт, согтуугаар жолоодсон болон жолоодох эрхгүй жолоодсон зөрчлийн чиг хандлагад бүс, аймаг, дүүргээр тогтмол дүн шинжилгээ хийх.



МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26-75-33
Цахим шуудан: info@mojha.gov.mn
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.08.14 № 1/4338
танай _____ -ны № _____ -т

Г Хариу хүргүүлэх тухай Г

Улсын Их Хурлын Гишүүн Ж.Баярмаагаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж гаргасан “Зам тээврийн ослын нөхцөл байдал, түүнийг бууруулах талаар” асуулгад холбогдох мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

1.2026 оны Үндэсний их баяр наадмын амралтын өдрүүдэд улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн осол, түүнээс шалтгаалсан нас баралт, гэмтлийн дэлгэрэнгүй статистикийг аймаг, нийслэл, замын чиглэл, нас, хүйс, тээврийн хэрэгслийн төрлөөр гаргасан судалгаа (Хавсралт-1);

2.Үндэсний их баяр наадмын үеийн зам тээврийн 2021-2025 оны ослын статистик, түүнд хийсэн дүн шинжилгээ (Хавсралт-2);

3.Ослын үндсэн шалтгааны ангилал тус бүрээр нь (хурд хэтрүүлсэн, согтууруулах ундаа хэрэглэсэн, гүйцэж түрүүлэх, ядаргаа, хамгаалах бүс, техникийн бүрэн бус байдал, замын нөхцөл байдал, замын нөхцөл, тэмдэг тэмдэглэгээ, мал амьтан, цаг агаар болон бусад) гаргасан тоо, хувь бүхий судалгаа (Хавсралт-3);

4.Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд бүртгэгдсэн замын хөдөлгөөний аюулгүй байдлын гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ, судалгаа хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх арга зам, цаашдын чиг хандлага, хэтийн төлөвийг тодорхойлж, шийдвэр гаргах зорилгоор “Дүн шинжилгээ, судалгааны баг”-ийг байгуулан зам тээврийн осол, зөрчлийг бууруулах ажил арга хэмжээг зохион байгуулж байна. Тухайлбал:

-Зам тээврийн осол, хэрэг их гардаг газар, байршлын судалгаанд үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024-2025 онд авто замын хэвтээ, босоо тэнхлэгийн дагуу “Орон нутгийн замын хөдөлгөөний хяналтын хурд хэмжигч, зөрчлийн телекамер”-ын 70 цэгийг ашиглалтад оруулсан;

-Улаанбаатар хотоос гадагш 150 км радиуст гарч байгаа зам тээврийн ослын улмаас хүний амь хохирох, гэмтэх тохиолдол, их гардаг хэсгүүдэд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор “Хөдөлгөөнт хяналтын тасаг”-ийг байгуулж, 24 цагийн хөдөлгөөнт эргүүлийн хяналтыг зохион байгуулснаар тухайн орчимд 2025 оны байдлаар бүртгэгдсэн зам тээврийн осол, хэрэг 14,7 хувь, хүний амь нас хохирсон тохиолдол 37,9 хувь, гэмтсэн хүн 29,5 хувь, мөргөлдөх хэлбэрээр үйлдэгдсэн зам тээврийн осол 13,6 хувь, онхолдох хэлбэрээр үйлдэгдсэн зам тээврийн осол 37,1 хувиар тус тус буурсан, 2026 оны эхний хагас жилийн байдлаар бүртгэгдсэн зам тээврийн осол, хэрэг 15,4 хувь, хүний амь нас хохирсон тохиолдол 50,0 хувь, гэмтсэн хүн 40,0 хувь, мөргөлдөх хэлбэрээр үйлдэгдсэн зам тээврийн осол 18,2 хувь, онхолдох хэлбэрээр үйлдэгдсэн зам тээврийн осол 42,2 хувиар тус тус буурсан эерэг үр дүн гарсан;

-Зам тээврийн осол гарахад зам, замын байгууламжийн аюулгүй байдал чухал нөлөөтэй бөгөөд мэргэжлийн байгууллагатай хамтарсан үзлэг шалгалтыг тогтмол зохион байгуулж, холбогдох чиг үүргийн байгууллага, албан тушаалтны хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, замын эвдрэл гэмтлийг засах, тэмдэг, тэмдэглэлийг сайжруулах, нойр сэргээгч, амрах бүс, аюулгүйн зогсолтын зурвас байгуулах арга хэмжээг авсан.

-Улаанбаатар, Төв, Булган, Өвөрхангай, Архангай, Завхан, Увс зэрэг 6 аймгийн 2026,3 км олон улс, улсын чанартай авто замд, Зам, тээврийн сайдын баталсан удирдамжийн дагуу "Улаанбаатар-Говьсүмбэр, Дорноговь-Замын үүд босоо тэнхлэгийн А0101, А0102, А0103 чиглэлийн авто замуудад үзлэг шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах зөвлөмж хүргүүлсэн, орон нутгийн авто замын үзлэг шалгалтуудыг зохион байгуулж 2025 онд 21 аймгийн Засаг даргын Тамгын газарт албан мэдэгдэл хүргүүлж 133,582м² зам засварын ажлыг хийлгэж, 558 тэмдгийг шинээр байрлуулж, 212 тэмдгийг засварлуулах ажлуудыг хийсэн.

-Зам тээврийн осол ихээр гардаг цэгүүдийн судалгаа мэдээлэлд үндэслэж 2025 онд тухайн осол гардаг хэсгүүдийг хяналтад авах зорилгоор "Шугаман эргүүл-Хар хэсэг" болон "Цагийн менежмент" арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 09 дүгээр сарын 23-ны өдрийг хүртэлх 135 хоногийн хугацаанд зохион байгуулсны үр дүнд хяналтад авсан 7,833 км хатуу хучилттай авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 40.2 хувиар, амь хохирсон тохиолдол 34.2 хувиар, гэмтсэн хүн 47.4 хувиар тус тус буурсан зэрэг үзүүлэлт гарсан.

5.Зуны улиралд нийслэлээс орон нутаг, аялал жуулчлалын бүс нутгийг чиглэсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн эрс нэмэгдэж, улмаар орон нутгийн авто замд зам тээврийн осол гарах, хүний амь нас, эрүүл мэнд хохирох эрсдэл нэмэгддэг. Ялангуяа тээврийн хэрэгслийн хурд хэтрүүлэх, гүйцэж түрүүлэх үйлдлийг буруу хийх, согтуугаар болон ядарч, нойрмог үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, хамгаалах бүс хэрэглэхгүй байх зэрэг жолоочийн сахилга, хариуцлагатай холбоотой зөрчил нь осол, эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Үүнтэй холбогдуулан цагдаагийн байгууллагаас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд оролцогчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор мэдээлэл нөлөөлөл, соён гэгээрүүлэх, хяналт шалгалт болон урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг жил бүр зохион байгуулсан байна. Тухайлбал, 2019 оноос эхлэн тухайн жилийн нөхцөл байдал, осол, зөрчлийн шалтгаан, эрсдэлийн онцлогт тулгуурлан "Яараад яахав дээ", "Дураараа биш дүрмээрээ", "Ирээдүйгээ хамгаалъя", "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ", "Нэг зам-Нэг соёл", "Амь аврах алтан гурвалжин", "Шугаман эргүүл-Хар хэсэг", "Дүрмээ мөрдье", "Амраад аюулгүй аялъя" зэрэг нөлөөллийн аян, арга хэмжээг зохион байгуулж байна.

Дээрх арга хэмжээний хэрэгжилтийн хугацаанд өмнөх оны мөн үетэй харьцуулахад зам тээврийн ослын улмаас хүний амь нас хохирсон болон гэмтсэн үзүүлэлтүүдэд тодорхой зэрэг өөрчлөлт гарсан байна. Үүнд:

-2019 онд (06 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 23-ны өдрийн хооронд) "Яараад яахав дээ", "Дураараа биш дүрмээрээ" арга хэмжээний хүрээнд нийт зам тээврийн осол 50.8 хувиар, ослоор амь насаа алдсан хүний тоо 11.7 хувиар, гэмтсэн хүний тоо 49.7 хувиар тус тус буурсан;

-2020 онд (07 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдрийн хооронд) "Яараад яахав дээ" арга хэмжээний хүрээнд нийт осол 22.4 хувиар, амь нас хохирсон хүний тоо 23.4 хувиар, гэмтсэн хүний тоо 26.9 хувиар тус тус буурсан;

-2021 онд (06 дугаар сарын 25-ны өдрөөс 08 дугаар сарын 10-ны өдрийн хооронд) "Ирээдүйгээ хамгаалъя" арга хэмжээний хүрээнд нийт осол 5 хувиар, амь нас хохирсон хүний тоо 33.3 хувиар, гэмтсэн хүний тоо 25.5 хувиар тус тус буурсан;

-2022 онд (06 дугаар сарын 20-ны өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд) "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ" арга хэмжээний хүрээнд нийт осол 8.1 хувиар, гэмтсэн хүний тоо 0.1 хувиар буурсан хэдий ч амь нас хохирсон хүний тоо 59.2 хувиар өссөн;

-2023 онд (06 дугаар сарын 30-ны өдрөөс 08 дугаар сарын 18-ны өдрийн хооронд) "Нэг зам- Нэг соёл" арга хэмжээний хүрээнд нийт осол 17.9 хувиар, амь нас хохирсон хүний тоо 5.7 хувиар, гэмтсэн хүний тоо 6.3 хувиар өссөн;

-2025 онд (06 дугаар сарын 23-ны өдрөөс 07 дугаар сарын 21-ний өдрийн хооронд) "Дүрмээ мөрдье" арга хэмжээний хүрээнд нийт осол 17.7 хувиар, амь нас хохирсон хүний тоо 35.7 хувиар буурсан боловч гэмтсэн хүний тоо 9.8 хувиар өссөн байна.

6.2021–2025 оны зам тээврийн ослын нөхцөл байдлын дүн шинжилгээнээс үзэхэд ослын тоо зарим жилд буурсан боловч, хүний амь нас хохирох болон гэмтэл буураагүй бөгөөд 2021 онд 383 хүн нас барсан бол 2025 онд 634 хүн нас барсан бөгөөд 2024 онд 631 хүн нас барсан үзүүлэлттэй харьцуулахад 2025 онд ослын нийт тоо 20.7 хувиар буурсан хэдий ч нас баралт 0.5 хувиар өссөн байна. Энэ нь зохион байгуулсан арга хэмжээ, зөвлөмжүүд нь тодорхой үр дүн өгсөн боловч, суурь шалтгааныг бүрэн арилгаж, эрсдэл дахин үүсэхээс урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй байгааг харуулж байна.

2025 оны байдлаар улсын хэмжээнд бүртгэгдсэн 24,574 зам тээврийн ослын 23,600 буюу 96.0 хувь нь жолоочийн буруутай үйлдлээс, 877 буюу 3.6 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 97 буюу 0.4 хувь нь замын нөхцөл болон техникийн гэмтлээс шалтгаалсан байна. Эндээс үзэхэд жолоочийн сахилга, хариуцлага, анхаарал болгоомж, хурд, согтуугаар жолоодох зэрэг хүний хүчин зүйлтэй шууд холбоотой байна. 2025 онд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсонтой холбоотой 2,286 осол бүртгэгдсэн бөгөөд энэ нь жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан ослын 9.3 хувийг эзэлж байна.

"Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 86 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хариуцсан нутаг дэвсгэрийнхээ нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг нэгдсэн сүлжээнд холбох, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа теле камерын стандартад нийцүүлэх, "Теле камерын хяналтын дэд төв"-д холбох боломжийг судалж, шийдвэрлэх талаар чиглэл хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагаас төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагатай хамтран 2026 оны 05 дугаар сарын 28-аас 06 дугаар сарын 04-ний өдрийн хугацаанд зам тээврийн осол ихээр гардаг /хар цэг/-үүдэд тодорхойлж, дундаж хурдны камерын систем байршуулах боломжтой, дэд бүтцэд холбогдсон 8 аймгийн 36 байршлыг тодорхойлон, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх талаар Засгийн газрын 2026 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит бус хуралдаанд танилцуулсан.

Засгийн газрын 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар зам тээврийн осол, нас баралт болон хүнд гэмтлийг бууруулах, НҮБ-ын Ерөнхий ассамблейн тогтоол, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай конвенц зэрэг олон улсын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, салбар хоорондын уялдааг сайжруулах үүрэг бүхий Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийг байгуулсан. Үндэсний зөвлөлийг дахин сэргээсэн нь давтагдсан эрсдэлийг салбар дундын түвшинд нэгтгэн удирдах, байгууллагуудын уялдаа холбоо, хариуцлагыг сайжруулах, олон улсын болон дотоодын эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг нэгдсэн байдлаар хангах чухал алхам болж байна.

7.Цагдаагийн байгууллагаас Замын хөдөлгөөний аюулгүй байдлын удирдлага, холбогдох байгууллагуудын чиг үүргийн уялдаа, мэдээлэл солилцоо, хариуцлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр дараах ажил, арга хэмжээг хамтран зохион байгуулсан байна. Тухайлбал;

-Тээврийн хэрэгслийн техникийн ерөнхий шаардлага Монгол Улсын стандарт MNS 4598:2025 шинэчлэн баталсан. Тус стандартыг шинэчлэн боловсруулахдаа "Овор ихтэй ачааны тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага" MNS 5345:2011, "Хүнд даацын тээврийн хэрэгсэл. Техникийн ерөнхий шаардлага" MNS 6278:2011 стандартуудын шаардлагыг нэгтгэн тусгаж, тээврийн хэрэгслийн ангилал, техникийн байдалд тавих ерөнхий шаардлагыг нэгдсэн байдлаар зохицуулах эрх зүйн үндэс бүрдэж, бүх төрлийн тээврийн хэрэгслийг L, M, N, O, T, C, R, S, G, P, LS, V зэрэг ангилалд хамааруулж, техникийн ерөнхий шаардлагуудыг тодорхой болгож өгсөн бөгөөд стандартын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулсан.

-Өсвөр насны хүүхэд, залуучууд цахилгаан хөдөлгүүрт унадаг дугуй, скутер, мопед, мотоцикл унаж, замын хөдөлгөөнд оролцох явдал эрс нэмэгдэж, зам тээврийн осолд өртөж өөрт болон бусдад эрүүл мэнд, эд материалын хохирол учруулах нөхцөл байдалтай холбоотойгоор Хууль зүй дотоод хэргийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны А/177/А/130 дугаартай хамтарсан тушаалаар "Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм"-д нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулж, Засгийн газрын 2025 оны 263 дугаар тогтоолоор "хөдөлгүүрийн ажлын багтаамж буюу чадал, эсхүл техникийн дээд хурд нь мопедынхоос илүү, хоёр дугуйт механикжсан тээврийн хэрэгслийг" нэмэлтээр оруулсан.

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгаар Дэлхийн банкны санхүүжилтээр "Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр" төслийн хүрээнд Улаанбаатар хотын хэмжээнд "Зам тээврийн ослын бүртгэл, мэдээллийн систем хөгжүүлж, суурилуулах зөвлөх үйлчилгээ STRA C-7" төслийг хэрэгжүүлж, TRL Technologies India Private Limited компани зүгээс "Зам тээврийн ослын бүртгэл, мэдээллийн шинэ платформ болон хөдөлгөөнт төхөөрөмжийн аппликейшн"-ыг хөгжүүлж байна.

-Нэгдсэн Үндэстний Байгууллагын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын сангийн дэмжлэгтэйгээр "Монгол Улс дахь замын аюулгүй байдалд хийх хөрөнгө оруулалт: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний төсөв, хөрөнгө оруулалтын стратегийг боловсруулах нь" төслийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Зам, тээврийн яамтай хамтран хэрэгжүүлж байна.

-“Ухаалаг Улаанбаатар хот” төслийн хүрээнд Нийслэл хотын 135 уулзвар, 41 явган хүний гарц, нийт 176 байршилд “AI” бүхий хиймэл оюун ухаанд суурилсан 2606 хяналтын камерыг суурилуулж, холбох ажлыг дуусган зөрчил илрүүлэх ажилд “Өгөгдөл боловсруулах-IREX” системийн программыг нэвтрүүлж, Монгол Улсын Засгийн газрын 239 дүгээр тогтоолоор батлагдсан Замын хөдөлгөөний дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох ажлыг эхлүүлсэн.

-Зам тээврийн ослын даатгалтай тохиолдолд мэдээлэл, баримтыг цахимаар автоматжуулсан системээс хүлээн авч, нөхөн төлбөрийг шийдвэрлэх талаар сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор Албан журмын даатгагчдын холбоо болон даатгагч байгууллагуудыг нэгтгэж дуудлага, мэдээллийг шуурхай хүлээн авах “Call center” буюу дуудлага, мэдээллийн төвийг байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамд тусгай дугаар олгох хүсэлтийг хүргүүлээд байна.

8.Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2026 онд 06 дугаар сарын 15-ны өдрөөс 07 дугаар сарын 25-ны өдрийн хооронд “Амраад аюулгүй аялъя” арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд нийт осол 5.7 хувиар, амь нас хохирсон хүний тоо 5.7 хувиар өссөн боловч, бүртгэгдсэн зам-тээврийн осол 17.8 хувиар, гэмтсэн хүн 5.6 хувиар, хүүхэд өртөж гэмтсэн осол 3.9 хувиар тус тус буурсан.

Арга хэмжээний хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагуудтай хамтран авто замын 717 тэмдэг шинээр байрлуулж, 421 тэмдэг засварласан бол 54,469 м.куб авто замд засвар арчлалт хийгджээ.

Олон улсын болон улсын чанартай авто зам болон сум суурин, аялал жуулчлалын бүс нутгийг холбосон авто замуудад 185 цэгт 520 алба хаагч үүрэг гүйцэтгэж, нийт 177350 тээврийн хэрэгсэлд үзлэг, шалгалт хийж 141,760 зөрчил илрүүлжээ.

Дээрх үзүүлэлтээс үзэхэд баяр наадмын үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх, мэдээлэл, нөлөөллийн арга хэмжээ нь зам тээврийн осол, түүнээс үүдэлтэй хохирлыг бууруулахад тодорхой үр нөлөө үзүүлж байгаа хэдий ч ослын улмаас хүний амь нас хохирох эрсдэл бүрэн буураагүй байна. Нийт ослын тоо буурсан жилүүдэд ч амь нас хохирсон хүний тоо өссөн үзүүлэлт гарсан нь ослын хүндрэлийн түвшин, осол гарах нөхцөл, шалтгаан, эрсдэлийн хүчин зүйлд чиглэсэн арга хэмжээг илүү нарийвчлан хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэд, олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, зам орчны аюулгүй байдлыг сайжруулж, олон улсын стандартад нийцүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх талаар үе шаттай ажил, арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна.

- 1 дүгээр хавсралт: 1 дүгээр хавсралт, 1 хуудастай.
- 2 дугаар хавсралт: 2 дугаар хавсралт, 6 хуудастай.
- 3 дугаар хавсралт: 3 дугаар хавсралт, 4 хуудастай.



Хууль зүй, дотоод хэргийн яам
Удирдлага
Сайд
Сайнбуян Амарсайхан
2026.08.25 16:47

1. УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ (2026 оны эхний 07 сарын үзүүлэлт)

Үзүүлэлт	2026	2025	Өөрчлөлт
Нийт бүртгэгдсэн дуудлага	75,499		
Нийт бүртгэгдсэн осол	13,434	14,500	-7.4%
Нас баралт	367	344	+6.7%
Гэмтсэн хүн	1,914	2,117	-9.6%
Бүртгэгдсэн гэмт хэрэг	2,815	2,686	+4.8%

- Нийт ослын 76.3% нь зөвхөн орон нутгийн замд бүртгэгдсэн.
- Ослын нийт тоо буурсан боловч хүний амь нас хохирсон осол болон бодит нас баралтын эрсдэлд анхаарах шаардлагатай.
- Гэмтсэн хүний тоо 9.6%-аар буурсан нь зэрэг үзүүлэлт байна.

2. ХАНГАЙН БҮС (Архангай, Баянхонгор, Өвөрхангай)

Осол	Нас барсан	Гэмтсэн	Гэмт хэрэг
201	41	74	236

Гол шалтгаан:

- Зогсоох арга хэмжээ аваагүй – 45
- Анхаарал болгоомжгүй үйлдэл – 40
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон – 36
- Эсрэг урсгалд орсон – 10

Дүгнэлт, анхаарах асуудал:

- Осол өмнөх оноос 24.4 хувиар буурсан.
- 41 нас баралтын 22 буюу 53.7% нь онхолдох хэлбэрээр үйлдэгдсэн.
- Архангай аймаг бүсийн өндөр үзүүлэлттэй боловч илрүүлсэн зөрчил бага байна.

3. БАРУУН БҮС (Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд)

Осол	Нас барсан	Гэмтсэн	Гэмт хэрэг
362	37	101	330

Гол шалтгаан:

- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон – 77
- Анхаарал болгоомжгүй үйлдэл – 71
- Зогсоох арга хэмжээ аваагүй – 43
- Ухрах үйлдэл буруу хийсэн – 19

Дүгнэлт, анхаарах асуудал:

- Ховд аймагт нас барсан хүний тоо 62.5 хувиар өссөн.
- Ховд аймгийн гэмт хэргийн өсөлт бүсийн үзүүлэлтэд голлон нөлөөлсөн.
- Алслагдсан урт шулуун замд хурд, согтуугаар жолоодох хяналтыг эрчимжүүлэх шаардлагатай.

4. ХОЙД БҮС (Булган, Орхон, Хөвсгөл)

Осол	Нас барсан	Гэмтсэн	Гэмт хэрэг
293	40	69	247

Гол шалтгаан:

- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон – 47
- Зогсоох арга хэмжээ аваагүй – 38
- Уулзвар, гарц нэвтрэх журам зөрчсөн – 34
- Явган зорчигчид зам тавьж өгөөгүй – 16

Дүгнэлт, анхаарах асуудал:

- Осол буурсан боловч Хөвсгөл, Булган аймагт үзүүлэлтүүд өндөр өсөлттэй.
- Аялал жуулчлал, хөдөлгөөн ихтэй чиглэлд хурд, гүйцэж түрүүлэх хяналтыг нэмэгдүүлэх.
- Сургууль, хүүхдийн хөдөлгөөн ихтэй хэсгийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх.

5. ТӨВИЙН БҮС

(Дархан-Уул, Сэлэнгэ, Төв)

Осол	Нас барсан	Гэмтсэн	Гэмт хэрэг
609	60	143	324

Гол шалтгаан:

- Анхаарал болгоомжгүй – 146
- Зогсоох арга хэмжээ аваагүй – 128
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон – 80
- Хажуу хоорондын зай тохируулаагүй – 59

Дүгнэлт, анхаарах асуудал:

- Нийт дүнгээр осол, нас баралт, хүүхэд өртсөн осол буурсан зэрэг үзүүлэлттэй.
- Төв аймагт нас барсан хүний тоо 12.9%-аар өссөн.
- Төв аймагт онхолдох хэлбэрийн 204 осол бүртгэгдсэн.

6. ЗҮҮН БҮС

(Дорнод, Сүхбаатар, Хэнтий)

Осол	Нас барсан	Гэмтсэн	Гэмт хэрэг
309	32	57	321

Гол шалтгаан:

- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон – 85
- Анхаарал болгоомжгүй – 76
- Зогсоох арга хэмжээ аваагүй – 36
- Уулзвар, гарц нэвтрэх журам зөрчсөн – 20

Дүгнэлт, анхаарах асуудал:

- Осол өмнөх оноос 22.4%-иар буурсан.
- Сүхбаатарын осол, хохирол болон Хэнтийн нас баралт өссөн.
- Согтуугаар жолоодох зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох хяналтыг эрчимжүүлэх шаардлагатай.

7. ГОВИЙН БҮС

(Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь)

Осол	Нас барсан	Гэмтсэн	Гэмт хэрэг
------	------------	---------	------------

558	70	93	302
-----	----	----	-----

Гол шалтгаан:

- Анхаарал болгоомжгүй – 113
- Зогсоох арга хэмжээ аваагүй – 80
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон – 61
- Гүйцэж түрүүлэх үйлдэл буруу хийсэн – 24

Дүгнэлт, анхаарах асуудал:

- Осол, хүний амь нас хохирсон осол болон нас баралт өссөн.
- Өмнөговь аймгийн өсөлт бүсийн нийт үзүүлэлтэд голлон нөлөөлсөн.
- Уул уурхай, экспортын чиглэлд хүнд даацын тээврийн хэрэгсэл, хурд, жолоочийн ажил-амралтын горимд хяналт шаардлагатай.

8. НИЙСЛЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

(6 дүүрэг, 2026 оны эхний 07 сар)

Дүүрэг	Осол	Нас барсан	Гэмтсэн	Хүүхэд өртсөн осол	Гэмт хэрэг
Баянгол	1,753	8	189	44	125
Баянзүрх	3,649	18	372	96	263
Сүхбаатар	1,379	5	199	47	106
Сонгинохайрхан	1,488	27	231	59	214
Хан-Уул	2,170	18	231	65	169
Чингэлтэй	519	4	134	31	109

- Осол өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар, хүүхэд өртсөн осол 11.2 хувиар, хүүхдийн нас баралт 27.3 хувиар буурсан.
- Хүний амь нас хохирсон осол 14.9 хувиар, бодит нас баралт 14.5 хувиар, бүртгэгдсэн гэмт хэрэг 1.0 хувиар өссөн.
- Сонгинохайрхан дүүрэг хамгийн өндөр нас баралттай 27; явган зорчигчийн нас баралт 19.
- Баянзүрхэд гэмт хэргийн тоо 263 буюу хамгийн өндөр, Баянгол, Сонгинохайрханд урьдчилан сэргийлэх арга хэмжээг түлхүү чиглүүлэх шаардлагатай.

9. АЛСЛАГДСАН 3 ДҮҮРЭГ

(Багануур, Багахангай, Налайх)

Дүүрэг	Осол	Нас барсан	Гэмтсэн	Хүүхэд өртсөн осол	Гэмт хэрэг
Багануур	26	1	14	11	32
Багахангай	10	0	1	1	2
Налайх	108	6	6	3	35

- Багануурт хүүхэд өртсөн осол 5.5 дахин, гэмтсэн хүүхдийн тоо 6.5 дахин өссөн.
- Налайхад хүний амь нас хохирсон осол өсөж, гэмт хэрэг 2.3 дахин нэмэгдсэн.
- Багахангайд нөхцөл байдал тогтвортой байна.
- Багануур, Налайхад хурд хэтрүүлэх, согтуугаар жолоодох зөрчлийн хяналт болон хүүхдийн аюулгүй байдлын арга хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Улсын хэмжээнд ослын нийт тоо буурсан боловч, нас баралтын үзүүлэлт өссөн тул хүний амь нас хохирсон ослын эрсдэлийг бууруулахад хяналт, урьдчилан сэргийлэлтийг чиглүүлэх.

Орон нутгийн урт шулуун болон хөдөлгөөн ихтэй авто замд хурд хэтрүүлэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, гүйцэж түрүүлэх үйлдэлд чиглэсэн хяналтыг эрчимжүүлэх.

Говийн бүсэд уул уурхай, экспортын тээврийн чиглэлд хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хурд, жолоочийн ажил-амралтын горимд тавих хяналтыг нэмэгдүүлэх.

Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол дүүргүүдийн явган зорчигч болон хүүхэд өртөх эрсдэлтэй цэгүүдэд урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг түлхүү хэрэгжүүлэх.

Сургууль орчим, хүүхдийн хөдөлгөөн ихтэй хэсэг, явган хүний гарц болон эрсдэл өндөртэй цэгүүдийн аюулгүй байдлыг сайжруулах.

Зөрчлийн илрүүлэлт, согтуугаар жолоодсон болон жолоодох эрхгүй жолоодсон зөрчлийн чиг хандлагад бүс, аймаг, дүүргээр тогтмол дүн шинжилгээ хийх.

---oOo---

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ӨДРҮҮДЭД БҮРТГЭГДСЭН
ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ**
(2021-2026 оны статистик мэдээнд үндэслэсэн тайлан)

1.Товч танилцуулга

Энэ тайланд Үндэсний их баяр наадмын өдрүүдэд (2021-2026 он) бүртгэгдсэн зам тээврийн ослын тоо, ослоор нас барсан, гэмтсэн хүний тоог он оноор, мөн бүс нутаг, тээврийн хэрэгслийн төрөл, хохирогчийн хэлбэр (жолооч/зорчигч/явган зорчигч/дугуйтай хүн), нас, хүйсээр задлан шинжилсэн болно. Эцэст нь дүн шинжилгээнд үндэслэн баяр наадмын өдрүүдэд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх практик санал зөвлөмжийг боловсруулав.

2.Ерөнхий чиг хандлага (2021-2026)

2021-2024 онд осол, нас барсан, гэмтсэн хүний тоо тогтмол огцом өсч, 2024 онд бүх үзүүлэлт хамгийн өндөр түвшинд хүрсэн. 2025-2026 онд ослын тоо бага зэрэг буурсан хэдий ч 2021 оны түвшнээс 7-8 дахин их хэвээр байна.



Зураг 1. Наадмын өдрүүдэд бүртгэгдсэн осол, нас барсан, гэмтсэн хүний тоо (2021-2026)

Он	Осол	Өсөлт/бууралт	Нас барсан	Өсөлт/бууралт	Гэмтсэн	Өсөлт/бууралт
2021	34	—	3	—	1	—
2022	149	+338.2%	8	+166.7%	21	+2000.0%
2023	246	+65.1%	11	+37.5%	42	+100.0%
2024	332	+35.0%	21	+90.9%	59	+40.5%
2025	290	-12.7%	8	-61.9%	67	+13.6%
2026	266	-8.3%	16	+100.0%	62	-7.5%

Гол ажиглалт:


- Осол 2021-2024 онд 34-өөс 332 болж ~10 дахин өссөн; 2025-2026 онд 290, 266 болж бага зэрэг буурсан ч өндөр хэвээр байна.

- Нас барсны тоо 2024 онд 21 хүнд хүрч оргил цэгт хүрсэн, 2025 онд 8 хүн болж огцом буурсан, харин 2026 онд дахин 16 хүн болж 2 дахин өссөн нь эргэлт буцалттай өөрчлөлт байгааг харуулж байна.

- Гэмтсэн хүний тоо 2021-2025 онд тасралтгүй өссөн (1→67), 2026 онд бага зэрэг (62) буурсан.

3.Бүс нутгаар (Аймаг, Нийслэл)

Нийслэлд бүртгэгдсэн ослын тоо жил бүр аймгийн нийт ослоос 2-3 дахин их байна. Энэ нь Улаанбаатар хотод тээврийн хэрэгслийн төвлөрөл, замын хөдөлгөөний нягтшил өндөр байгаатай холбоотой гэж дүгнэж болно. Гэвч 2022 оноос хойш аймгийн ослын тоо ч мөн тогтмол өссөн (63→89) хэдий ч 2026 онд арай буурсан (70)



Зураг 2. Аймаг, Нийслэлээр бүртгэгдсэн осол (2021-2026)

Он	Аймаг	Нийслэл	Нийт
2021	0	34	34
2022	63	86	149
2023	78	168	246
2024	80	252	332
2025	89	201	290
2026	70	196	266

4.Тээврийн хэрэгслийн төрлөөр

Суудлын автомашин жил бүр ослын дийлэнх хувийг (78-86%) эзэлж байгаа бол ачааны машин 7-12%, мотоцикл 3-6% байна. 2026 онд механизм болон мотоциклын ослын хувь харьцангуй тогтвортой байгаа хэдий ч мотоциклтой холбоотой нас баралт (доор 5-р хэсэгт) сүүлийн жилүүдэд өссөн нь анхаарал татаж байна.



Зураг 3. Ослын тээврийн хэрэгслийн төрлөөр хуваарилалт (2021-2026)

Он	Суудлын	Ачааны	Автобус	Механизм	Мотоцикл	Унадаг дугуй	Бусад
2021	27 (79%)	4 (12%)	2 (6%)	0 (0%)	0 (0%)	1 (3%)	0 (0%)
2024	277 (83%)	26 (8%)	10 (3%)	0 (0%)	13 (4%)	3 (1%)	3 (1%)
2026	224 (84%)	25 (9%)	5 (2%)	1 (0%)	8 (3%)	1 (0%)	2 (1%)

5. Хохирогчийн бүлгээр (хэлбэр, нас, хүйс)

5.1. Явган зорчигчийн эрсдэл огцом өсч байна.

Гэмтсэн явган зорчигчийн тоо 2021-2022 онд бараг бүртгэгдээгүй байсан бол 2023 онд 11, 2024 онд 21, 2025 онд 34 болж хурдацтай өссөн (2026 онд 28). Энэ нь баяр наадмын өдрүүдэд явган зорчигчийн хөдөлгөөн, зам гарц, гэрэлтүүлэгийн дутагдалтай холбоотой байж болзошгүй тул тусгайлан анхаарах шаардлагатай асуудал юм.



Зураг 4. Явган зорчигчийн эрсдэл: гэмтсэн, нас барсан хүний тоо (2021-2026)

Он	Жолооч	Зорчигч	Явган зорчигч	Дугуйтай хүн
2021	0	1	0	0
2022	6	15	0	0
2023	6	23	11	2
2024	24	11	21	3
2025	12	17	34	4
2026	11	21	28	2

5.2.Насны бүлгээр:

18-34 насны залуу насны хүмүүс жил бүр хамгийн их тоогоор гэмтэж, нас бардаг бөгөөд энэ насны бүлэг нийт хохирогчдын дийлэнхийг эзэлж байна. Үүнээс гадна 0-17 насны хүүхэд, өсвөр насныхны гэмтэл 2022 оноос хойш огцом өссөн (6→19), энэ нь тэдний зам хөдөлгөөний аюулгүй байдалд илүү анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.



Зураг 5. Насны бүлгээр гэмтсэн хүний тоо (2021-2026)

Он	0-17	18-34	35-55	55-с дээш
2021	0	1	0	0
2022	6	8	3	4
2023	12	19	7	4
2024	13	19	18	9
2025	19	25	18	5
2026	17	19	17	9

5.3.Хүйсээр

Нас барсны 60-70 хувь эрэгтэй хүмүүс байдаг бол гэмтсэн хүмүүсийн хувьд эрэгтэй, эмэгтэй хүний харьцаа харьцангуй тэнцвэртэй (2026 онд эрэгтэй 42, эмэгтэй 20 буюу эрэгтэйчүүд арай их).

6.Дүгнэлт

Сүүлийн 6 жилийн статистикаас харахад Наадмын өдрүүдэд бүртгэгдэх зам тээврийн осол, хохирогчийн тоо 2021 оноос хойш мэдэгдэхүйц өссөн бөгөөд 2024 онд оргил цэгтэй, дараа нь бага зэрэг буурсан хэдий ч анхны түвшингээс хол зайд байна. Гол эрсдэлт хүчин зүйлс нь: (1) суудлын автомашины эрчимжсэн хөдөлгөөн, (2) Нийслэлийн замын ачаалал, (3) явган зорчигчийн өсөн нэмэгдэж буй эрсдэл, (4) 18-34 насны залуучуудын осолд өртөх өндөр давтамж, (5) мотоциклтой холбоотой нас баралтын сүүлийн үеийн өсөлт. Эдгээр хүчин зүйлсийг тусгасан зорилтот бодлого, урьдчилан сэргийлэх ажил шаардлагатай байна.

7.Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх санал зөвлөмж

Дээрх дүн шинжилгээнд үндэслэн Наадмын өдрүүдэд зориулсан дараах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

-Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтыг эрчимжүүлэх.

Наадмын өдрүүдэд Нийслэлд бүртгэгдэх осол тогтмол хамгийн их байдаг тул төв замууд, наадмын талбай орчимд цагдаа, замын хөдөлгөөний удирдамжийн ажилтныг нэмэгдүүлж, түгжрэл ихтэй цагуудад (өглөө, орой) хяналтыг эрчимжүүлэх.

-Согтууруулах ундаа хэрэглэсэн жолоочийг илрүүлэх шалгалтыг эрчимжүүлэх.

Наадмын баяраар архи, согтууруулах ундаа хэрэглэлт нэмэгддэг тул орой, шөнийн цагаар согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгах хөдөлгөөнт постыг нийслэл, аймгийн төв замуудад нэмэгдүүлэх.

-Явган зорчигчийн аюулгүй байдлыг сайжруулах.

Явган зорчигчийн гэмтэл сүүлийн жилүүдэд огцом өссөн тул наадмын талбай, зах, худалдаа наймаа төвлөрсөн газруудын ойролцоо явган хүний гарц, гэрэлтүүлэг, хамгаалалтын хашлагыг түр байдлаар нэмэгдүүлэх, шаардлагатай бол тодорхой хэсэгт хурд хязгаарлах, зорчигчийн замыг тусгаарлах.

-Мотоцикл жолоодох дүрэм, хамгаалах хэрэглэлийн хяналтыг чангатгах.

Мотоциклтой холбоотой нас баралт сүүлийн жилүүдэд өссөн тул малгай (дуулга) зүүх, үнэмлэхтэй жолоодох дүрмийн мөрдөлтийг шалгах тусгай ажиллагааг зохион байгуулах.

-18-34 насны залуу жолооч, зорчигчид чиглэсэн ухамсарын кампанит ажил.

Хамгийн их хохирогч бүхий насны бүлэг тул сошиал медиа, орон нутгийн телевиз, радио ашиглан хурд хэтрүүлэх, гар утас ашиглах, аюулгүйн бүслүүр зүүхгүй байх зэрэг эрсдэлтэй зан үйлийн эсрэг зорилтот сургалт, сэрэмжлүүлэг явуулах.

-Хүүхэд, өсвөр насныхны аюулгүй байдалд анхаарах.

0-17 насны хүүхдийн гэмтэл өссөн тул хүүхдийн суудал/аюулгүйн бүслүүрийн хэрэглээг эцэг эх, жолоочид сануулах, сургууль, орон нутгийн удирдлагатай хамтран зуны амралтын өдрүүдэд хүүхдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалт зохион байгуулах.

-Аймгийн болон хөдөө орон нутгийн замын аюулгүй байдлыг сайжруулах.

Аймгийн ослын тоо тогтвортой өндөр байгаа тул орон нутгийн зам, гарц, тэмдэг тэмдэглэгээг Наадмын өмнө нөхөн засварлах, шаардлагатай газарт хурд хязгаарлах тэмдэг байрлуулах, орон нутгийн цагдаагийн хүчийг бэхжүүлэх.

-Олон нийтийн тээврийг дэмжих, хувийн тээврийн ачааллыг бууруулах.

Наадмын үеэр наадмын талбай, зочид буудал, аймгийн чиглэлд нэмэлт шуудан/автобусны чиглэл зохион байгуулж, хувийн тээврийн хэрэгслийн хэт ачааллыг бууруулах замаар ослын эрсдэлийг бууруулах.

-Онцгой байдал, түргэн тусламжийн бэлэн байдлыг хангах.

Ослын тоо ихэссэн үед хохирлыг бууруулахад түргэн тусламжийн бригад, эмнэлгийн бэлэн байдлыг наадмын өдрүүдэд, ялангуяа их хэмжээний хүн цугларах газруудад нэмэгдүүлэх.

-Мэдээллийн тогтолцоог сайжруулж, жил бүр дүн шинжилгээ хийх.

Ослын мэдээллийг он, сар, цаг, байршил, шалтгаанаар нарийвчлан бүртгэж, Наадмын дараа үр дүнг тухайн жилийн урьдчилан сэргийлэх ажилтай харьцуулан үнэлж, дараа жилийн төлөвлөгөөнд тусгах тогтолцоог бэхжүүлэх.

—oOo—

ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБА

ТАНИЛЦУУЛГА

2026 оны 09 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

5.Баяр наадмын үеэр Засгийн газар, Цагдаа, Зам тээвэр, Эрүүл мэнд, Онцгой байдал болон орон нутгийн байгууллагуудаас зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан төсөв, үр дүнг байгууллага тус бүрээр гаргасан мэдээллийн талаар:

Энэ онд (06 дугаар сарын 25-ны өдрөөс 08 дугаар сарын 24-ний өдрийн хооронд) "Орон нутгийн зам хөдөлгөөний соёл" нэгдсэн арга хэмжээг 60 хоногийн хугацаанд зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд нийт бүртгэгдсэн зам тээврийн осол, хэрэг 57 нэгжээр буюу -6.9 хувиар, осол, хэргийн улмаас хүний амь хохирсон тохиолдол 2 нэгжээр буюу -2.0 хувиар тус тус буурч, хүн гэмтсэн тохиолдол 40 нэгжээр буюу 24.1 хувиар өссөн байна.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд (06 дугаар сарын 25-ны өдрөөс 07 дугаар сарын 25-ны өдрийн хооронд) "Амраад аюулгүй аялъя" нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд нийт осол 5.7 хувиар, амь нас хохирсон хүний тоо 5.7 хувиар өссөн боловч бүртгэгдсэн зам тээврийн осол -17.8 хувиар, гэмтсэн хүн -5.6 хувиар, хүүхэд өртөж гэмтсэн осол -3.9 хувиар тус тус буурсан үр дүнгүүд гарсан.

Арга хэмжээний хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагуудтай хамтран авто замын 717 тэмдэг шинээр байрлуулж, 421 тэмдэг засварласан бол 54,469 м.куб авто замд засвар арчлалт хийгджээ.

Олон улсын болон улсын чанартай авто зам болон сум суурин, аялал жуулчлалын бүс нутгийг холбосон авто замуудад 185 цэгт 520 алба хаагч үүрэг гүйцэтгэж, нийт 177350 тээврийн хэрэгсэлд үзлэг, шалгалт хийж 141,760 зөрчил илрүүлсэн.

Харин Үндэсний их баяр, наадмын өдрүүдэд буюу 07 дугаар сарын 10-ны өдрөөс 07 дугаар сарын 13-ны өдрийг дуустал хугацаанд орон нутгийн замд 85 осол хэрэг бүртгэгдэж, ослын улмаас 16 хүн гэмтэж, 4 хүний амь нас хохирсныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал бүртгэгдсэн зам тээврийн осол хэрэг 14 нэгжээр буюу 14,1 хувиар, хүн гэмтсэн тохиолдол 2 нэгжээр буюу 11,1 хувиар, хүний амь нас хохирсон тохиолдол 1 нэгжээр буюу 20,0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Үндэсний их баяр наадмын үеэр тус албанаас зам тээврийн осол, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр үүрэг гүйцэтгэсэн 618 алба хаагчийн хоолны зардалд 60,453,000 төгрөг, 134 автомашины шатахууны зардалд 18,290,000 төгрөг, нийт 78,743,000 (далан найман сая долоон зуун дөчин гурван мянган) төгрөгийн зардлыг Санхүү, ар талын албанаас шийдвэрлүүлж, албан хэрэгцээнд зориулан зарцуулсан болно.

ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБА



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251

Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,

Цахим шуудан: info@mrt.gov.mn,

Цахим хуудас: www.mrt.gov.mn

2026.09.01 № 01/4274

танай 2026.08.10-ны № ХЭГ/2698 -т

ГМОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН Ү
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХБАЯР
ТАНАА

Таны 2026 оны 08 дугаар сарын 10-ны
өдрийн "Асуулгын хариу бэлтгүүлэх тухай"
ХЭГ/2698 дугаартай албан бичгийн дагуу холбогдох
мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.



Зам, тээврийн яам

Сайд

Б.Дэлгэрсайхан

2026.09.01 12:38

Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах үүргийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөл хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 128 дугаар тогтоолоор баталсан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөл нь орон тооны бус бүрэлдэхүүнтэйгээр хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж байсан боловч Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 22 дугаар тогтоолоор Үндэсний зөвлөлийг татан буулгасан.

Сүүлийн 5 жилийн хугацаанд зам тээврийн осол, нас баралт, гэмтлийн тоо нэмэгдэж, тээврийн хэрэгслийн тоо, тэр дундаа скүүтер, суррон зэрэг шинэ төрлийн тээврийн хэрэгслийн хэрэглээ эрчимтэй өсөж байгаа нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр салбар хоорондын нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэх шаардлагыг бий болгож байна.

Энэ хүрээнд Зам, тээврийн яамнаас Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийг дахин байгуулах санал, Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын 2026 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийг дахин байгуулсан.

Цаашид Үндэсний зөвлөл нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг уялдуулах, зам тээврийн осол, зөрчил, эрсдэлийн талаарх мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийх, ослын шалтгаан, эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээнд чиглэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг хэрэгжүүлнэ.

Мөн байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг бодит үзүүлэлтэд үндэслэн үнэлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээ авах тогтолцоог боловсронгуй болгоно.

Ингэснээр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг нэгдсэн бодлого, удирдлага, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалт, салбар хоорондын уялдаа, хяналт-хариуцлагын тогтолцоонд тулгуурлан хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байна.